



Монгол Улс: Ухаалаг Засаг-2 төсөл

ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Төсөл хэрэгжүүлэх нэгж

2024 он

Агуулга

1. Оршил	3
2. Төслийн танилцуулга.....	4
3. Сонирхогч талуудыг олж тодорхойлох ба судлах.....	6
4. Аргачлал.....	9
5. Төслийн бэлтгэл ажлыг хангах явцад сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа	12
6. Мэдээллийг ил тод болгох.....	13
7. Хяналт шинжилгээ ба тайлагнал	14
8. Гомдол барагдуулах механизм	14
9. Байгаль орчин, нийгмийн менежментийн чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө	16

1. Оршил

Энэхүү баримт бичиг нь Ухаалаг засаг-2 төслийн (цаашид "Төсөл" гэх) Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ) юм. Энэхүү ТОХТ-ний гол зорилго нь төслийн бүхий л мөчлөгийн туршид олон нийтэд мэдээлэл түгээх, тэдэнтэй зөвлөлдөх замаар сонирхогч талуудын оролцоог хангах хөтөлбөрийг тодорхойлоход оршино. ТОХТ нь төслийн багийн зүгээс сонирхогч талуудтай харилцаа холбоотой байх арга замыг тодорхойлсон бөгөөд иргэд, олон нийт төсөл болон төсөлтэй холбоотой аливаа үйл ажиллагааны талаар анхаарал татсан асуудлаар санал бодлоо илэрхийлэх, санал хүсэлт болон гомдол гаргах механизмыг өөртөө агуулсан болно. Төслийн ажилтнууд болон орон нутгийн иргэд хоорондын тогтвортой хамтын ажиллагааг хангах, санал болгож буй төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг багасгах, бууруулахад орон нутгийн иргэдийн оролцоог хангах явдал төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. ТОХТ-г Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн цахим хуудсанд байршуулна.

Төслийн хүрээнд Олон улсын хөгжлийн ассоциацийн 40.7 сая ам.долларын зээлийг Дэлхийн банкнаас (цаашид "Банк" гэх) Сангийн яаманд олгохыг санал болгож байгаа юм. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь Цахим хөгжил, харилцаа холбооны яам байх бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам Төрийн худалдан авах ажиллагааны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Авлигатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төслийн үр шим хүртэгч байгууллагууд нь Цахим хөгжил, харилцаа холбооны яамны удирдлаган дор төслийн холбогдох бүрэлдэхүүн хэсэг/дэд бүрэлдэхүүн хэсэг болон салбарын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

ТОХТ-г төслийн сонирхогч буюу оролцогч талуудтай зөвлөлдөж, оролцогч талуудын¹ талаар судалгаа дүгнэлт хийсний үндсэн дээр боловсруулав. ТОХТ нь төслийн оролцогч талууд, төсөл хэрэгжих хугацаанд мэдээлэл түгээх, зөвлөлдөх арга болон санал гомдлыг барагдуулах арга замыг тодорхойлсон болно.

Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ) болон Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10-т² заасны дагуу талуудын оролцоог хангах нь дараах гол зорилгыг агуулна. Үүнд:

- Төслийн нөлөөлөлд өртөгч талуудыг олж тодорхойлон тэдэнтэй бүтээлч харилцаа тогтоох, хадгалахад туслах сонирхогч талуудын оролцоонд эмх журамтай буюу системтэйгээр хандах хандлагыг бий болгох.
- Төсөлд сонирхогч талуудын сонирхол, дэмжлэгийн түвшинд үнэлгээ хийж, төслийн дизайн болон байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд оролцогч талуудын саналыг харгалзаж үзэх боломжийг олгох.
- Төслийн нөлөөлөлд өртөгч талуудтай төслийн амьдралын мөчлөгийн туршид тэдэнд нөлөөлж болзошгүй асуудлыг шийдвэрлэхэд тэдний үр дүнтэй, хүртээмжтэй оролцоог хангах арга ухааны талаар сурталчлан таниулж, ийм арга замаар хангах.

¹ «Сонирхогч тал» гэдэг нь: (а) Төслийн нөлөөлөлд өртсөн эсхүл өртөх магадлалтай (төслийн нөлөөлөлд өртсөн талууд); ба (б) Төсөлд сонирхолтой байж болох талууд (бусад сонирхогч талууд) юм.

² Арга хэрэгслийг боловсруулах боломжийн үйл ажиллагаанд (IPF Operations) зориулсан Байгаль орчин, нийгмийн хүрээ. ESS10: Талуудын оролцоо ба мэдээллийг ил тод болгох, 2018.

- Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн талаарх төслийн зохих мэдээллийг оролцогч талуудад цаг тухайд нь, ойлгомжтой, хүртээмжтэй, оновчтой хэлбэр, форматаар ил болгох нөхцлийг бүрдүүлэх.
- Төслийн нөлөөлөлд өртөгч талуудыг асуудал дэвшүүлэх, гомдол гаргах хүртээмжтэй бөгөөд оролцоог хангасан арга хэрэгслээр хангах, төсөл хэрэгжүүлэгчид эдгээр гомдолд хариу өгөх, зохицуулах боломжийг олгох.

Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-нд Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10, «Сонирхогч талуудын оролцоо ба мэдээллийг ил тод болгох» багтдаг бөгөөд энэ нь «Зээлдэгч болон төслийн оролцогч талуудын хоорондын нээлттэй, ил тод оролцооны ач холбогдлыг олон улсын шилдэг туршлагын чухал хэсэг» хэмээн хүлээн зөвшөөрдөг. Төслийн баримт бичгийг 2021 оны 12-р сард Дэлхийн банкнаас эцэслэхээс өмнө 2021 оны 11-р сард урьдчилсан байдлаар сонирхогч талуудыг тодорхойлж, ТОХТ-г олон нийтэд нээлттэй мэдээлэн, сонирхогч талуудын саналыг авсан. БОНС10 нь гомдол барагдуулах механизмыг (ГБМ) боловсруулж хэрэгжүүлэхийг шаарддаг. Үндэсний зохицуулалтын шаардлага, түүнчлэн БОНХ-ний дагуу тавигдах шаардлагыг энд харгалзаж үзсэн болно.

Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10-аас гадна тухайн улс орны зүгээс сонирхогч талуудын оролцоог хангахтай холбоотой зохицуулалтад тавьдаг шаардлага гэж бий. Зөвлөлдөх, мэдээллийн ил тод байдлыг хангахад тавигдах Монгол Улсын зохицуулалтын шаардлагыг мөн энд авч үзсэн.

Төслийн санхүүжилтийг Дэлхийн банкнаас гаргахыг санал болгосон бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-нд тусгагдсан шаардлагыг хангахын тулд байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон бусад төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах шаардлагатай байгаа болно. Эдгээр үнэлгээ болон арга хэрэгслүүдэд дараах зүйлс орно. Үүнд:

- Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг)
- Хэрэгжилтэд мөрдөх байгаль орчны журам (ХМБОЖ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг)
- Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг)
- Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө (БОНАТ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг)
- Нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ННҮ нь төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй нийгэмд үзүүлэх нөлөөлөл, түүнчлэн төслийн үйл ажиллагааг төлөвлөхөд шаардлагатай мэдээлэл өгөх нийгмийн шалгуур, болон санал дүгнэлтэд үнэлгээ өгдөг)

2. Төслийн танилцуулга

Монгол Улсын Засгийн газар сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд улс орондоо үр өгөөжөө өгөхүйц дижитал хөгжлийн олон тооны санаачилга гаргаж ирсэн. Монгол Улсад төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2015-2022 онд хэрэгжүүлсэн эхний шатны Ухаалаг засаг төсөл (P130891, 19.4 сая ам. доллар) нь хамгийн сүүлийн үеийн санхүүжүүлсэн төслүүдийн нэг юм. Энэхүү хэрэгжиж буй төсөл нь дижитал үндэс суурийг тавьж, иргэдэд ихээхэн үр өгөөжөө өгсөн бөгөөд 2022 оны 8-р сард хэрэгжиж

дуусахдаа төсөл төлөвлөсөн бүхий л зорьсон үр дүндээ хүрсэн байна. Үүний дараагийн буюу “Ухаалаг засаг-2” төсөл, түүний дизайн нь эхний төслийн ололт, хэрэгжилтийн туршлага дээр суурилсан болно. Энэ нь зөвхөн Монгол Улсын дижитал засаглалыг цахимжуулалтын дараагийн үе шатад хүргэж, өргөжүүлээд зогсохгүй, улс орны эдийн засгийг төрөлжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дижитал технологид суурилсан ажлын байр, өсөлтийг хангах зорилгоор дижитал эдийн засгийг хөгжүүлэх асуудлыг төслийн хамрах хүрээнд оруулан өргөжүүлсэн юм.

Энэхүү төслийн “Төслийн хөгжлийн зорилго” (ТөХЗ) нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх төрийн цахим үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, дижитал үр чадвар, дижитал технологи бүхий ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. Төсөл нь дор тодорхойлсончлон, таван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Хүснэгт 14. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд ба дэд бүрэлдэхүүн хэсгүүд.

Бүрэлдэхүүн хэсэг	Дэд бүрэлдэхүүн хэсэг
<p>Бүрэлдэхүүн хэсэг 1: <i>Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх</i> (3 сая доллар)</p> <p>Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь дижитал засаглал, эдийн засаг, холболтын талаарх бодлого, зохицуулалтыг бэхжүүлж, Монгол Улсын дижитал шилжилтийн орчныг бүрдүүлнэ. Энэ нь улсын салбарт нийтлэг дэд бүтэц, платформ нэвтрүүлэхэд чиглэсэн өөрчлөлт, оролцогч талуудын удирдлагыг хэрэгжүүлнэ. Эцэст нь, уг бүрэлдэхүүн хэсэг нь иргэдийн төрийн бодлогод цахимаар оролцох оролцооны талаар сурталчлан таниулах буюу хөхиүлэн дэмжих замаар иргэдийн цахим оролцоонд дэмжлэг үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • 1.1. Дижитал шилжилтийн бодлого, дүрэм, журмыг сайжруулах. • 1.2. Төслийн дижитал засгийн чиглэлээрх хөрөнгө оруулалтуудад зориулсан өөрчлөлтийн болон оролцогч талуудын менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • 1.3. Иргэдийн цахим оролцоог хөхиүлэн дэмжих.
<p>Бүрэлдэхүүн хэсэг 2: <i>Дижитал засгийн шилжилтийг нэвтрүүлэх</i> (20 сая ам. доллар)</p> <p>Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь цахим Монгол буюу e-Mongolia портал дахь төрийн цахим үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлнэ. Ингэснээр иргэдэд илүү өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлэх ба хэрэглэгчид илүүтэй хэрсүүжнэ. Энэ нь эрчим хүчний хэмнэлттэй, найдвартай, аюулгүй дижитал дэд бүтцээр дамжуулан дижитал шилжилтийг хурдасгах зорилгоор Засгийн газрын үндэсний түвшний хоёр дата төвийг үндэсний үүлэн тооцооллын платформ болгон шинэчлэх болно.</p> <p>Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үндэсний кибер аюулгүй байдлын яаралтай тусламжийн багийг (ЗГ-ын нэн чухал мэдээллийн дэд бүтэц, дижитал хөрөнгийг хянах, хамгаалах) байгуулна.</p>	<ul style="list-style-type: none"> • 2.1. Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, үр ашигтай байдлыг дээшлүүлэх, стратегийн үйлчилгээ үзүүлэх. • 2.2. Үндэсний дата төв болон түүний Нөөц дата төвийг шинэчлэх • 2.3. Үндэсний кибер аюулгүй байдлын онцгоой нөхцөлд хариу арга хэмжээ авах Мэдээллийн аюулгүй байдлын баг (МАББ)-ийн чадавхыг нэмэгдүүлэх, Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бэхжүүлэх.
<p>Бүрэлдэхүүн хэсэг 3: <i>Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих</i> (16 сая доллар)</p>	<ul style="list-style-type: none"> • 3.1. Төрийн албан хаагчид, иргэдийн цахим үр чадварыг нэмэгдүүлэх

<p>Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд (i) төрийн албан хаагчид болон иргэдэд дижитал үр чадвар олгох сургалт явуулна, (ii) залуучуудад (ялангуяа эмэгтэйчүүдэд) 3000 дижитал технологи бүхий ажлын байр бий болгоно, (iii) жижиг, дунд үйлдвэрүүдэд (ЖДҮ) бүтээмж, өрсөлдөх чадвар болон үйл ажиллагааныхаа уян хатан байдлыг сайжруулахад чиглэсэн дижитал шийдлүүд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • 3.2. Залуучуудад зориулсан дижитал технологид суурилсан ажлын байр (3,000) бий болгох. • 3.3. Жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДБЭ) үйл ажиллагаандаа дижитал технологийн шийдлийг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
<p>Бүрэлдэхүүн хэсэг 4: <i>Төслийн менежментийн зохион байгуулалт</i> (2 сая ам.доллар; үүний дотор ЗГ-ын 1 сая ам. долларын мөнгөн бус хувь оролцоо)</p>	<ul style="list-style-type: none"> • 4.1. Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийг байгуулж ажиллуулна.
<p>Бүрэлдэхүүн хэсэг 5: <i>Болзошгүй онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ</i> (0 ам.доллар) Төслийн бүтцэд БОБУХАХ-г нэмж оруулсан.</p>	<p>Энэ нь анхлан “0” утгатай байх хэдий ч, хямрал эсхүл онцгой байдлын үед шуурхай хариу арга хэмжээ авах боломж олгох үүднээс төсөл хэрэгжих явцад санхүүжүүлж болно.</p>

3. Сонирхогч талуудыг оролцоог хангах тухай

Сонирхогч талуудын оролцоо нь төслийн амьдралын мөчлөгийн түршид явагддаг хүртээмжтэй үйл явц юм. Талуудын оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг амжилттай удирдахад чухал ач холбогдолтой бат бөх, бүтээлч, хариу үйлдэл үзүүлэх харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго агуулдаг. Төсөл боловсруулах үйл явцын эхний үе шатад сонирхогч талуудын оролцоо хамгийн үр дүнтэй байдаг. Энэ нь төслийн эхэн үеийн шийдвэр, төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага, мониторингийн салшгүй хэсэг нь юм.

Төслийн оролцогч талуудыг хувь хүн, бүлгүүд эсхүл бусад этгээдүүд гэж хуваан авч үздэг бөгөөд эдгээр нь:

(i) Төслийн шууд эсхүл шууд бус, эерэг эсхүл сөрөг нөлөөлөлд өртсөн, эсхүл өртөх магадлалтай (мөн "нөлөөлөлд өртөгч талууд" гэж нэрлэдэг); болон

(ii) Төсөлд сонирхолтой байж болох талууд ("сонирхогч талууд") юм. Эдгээрт төслийн улмаас ашиг сонирхол нь хөндөгдсөн байж болзошгүй, төслийн үр дүнд ямар нэгэн байдлаар нөлөөлөх магадлалтай хувь хүн эсвэл бүлгүүд орно.

Төслийг боловсруулах явцад сонирхогч талуудтай хамтран ажиллах, хэлэлцээ хийхдээ тухайн бүлгийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллах, өөрөөр хэлбэл төсөлтэй хамтран ажиллах явцад бүлгийн эрх ашгийг хамгаалах итгэл хүлээсэн хувь хүнийг олж тодорхойлох шаардлагатай байдаг. Иргэд, олон нийтийн төлөөлөл нь орон нутгийн нөхцөл байдлын талаар ач тустай ойлголт өгч, төсөлтэй холбоотой мэдээллийг түгээх гол суваг болж, төсөл болон зорилтот олон нийт, тэдгээрийн үүсгэсэн сүлжээг хооронд нь холбох үндсэн холбоос болж өгдөг. Ялангуяа үндэсний цөөнх /уугуул/ иргэдийн хувьд оролцогч талуудын оролцоог тэдгээр иргэдийн төлөөллийн байгууллага, орон нутгийн засаг захиргаатай хамтран явуулна.

Сонирхогч талуудын төлөөллийг баталгаажуулах (өөрөөр хэлбэл, тэд төлөөлж буй иргэд, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалахуйц хууль ёсны бөгөөд жинхэнэ гэдгийг батлах үйл явц) нь иргэд, олон нийтийн сонирхогч талуудтай холбоо тогтооход чухал үйл хэрэг хэвээр байна. Иргэд, олон нийтийн төлөөллийн хууль ёсны буюу үнэн зөв байдлыг, олон нийт дундаас санамсаргүй түүвэрлэж сонгосон төлөөлөлтэй албан бусаар уулзан ярилцаж, тэдний ашиг сонирхлыг хэн хамгийн үр дүнтэйгээр төлөөлж чадах талаар тэдгээрийн санал бодлыг сонссоноор баталгаажуулж болно.

Төслийн оролцогч талуудын эхний байдлаар гаргасан жагсаалт, тэдний сонирхол, бүлэг тус бүртэй хамтран ажиллахад тохиромжтой аргуудын жагсаалтыг боловсруулж 2021 оны 12-р сард төслийн гол талуудтай санал солилцсон.

Зөвлөлдөх уулзалт хийх оролцогч талуудын жагсаалтыг 2-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Олж тодорхойлсон сонирхогч буюу оролцогч талууд

Оролцогч талууд	Төсөлд гүйцэтгэх үүрэг	Оролцоо	Нөлөө
Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллага: Техникийн дизайн, зөвшөөрөл, төслийн удирдах зөвлөлийг удирдан ажиллах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Өндөр	Өндөр
Дэлхийн банк	Төслийг санхүүжүүлэх	Өндөр	Өндөр
	Төслийн зорилгыг ханган биелүүлж буй эсэхэд хяналт тавих.		
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Төслийн үр шимийг хүртэгч гол байгууллага: Техникийн дизайн, зөвшөөрөл, төслийн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах	Өндөр	Өндөр
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Төслийн үр шимийг хүртэгч гол байгууллага: Техникийн дизайн, зөвшөөрөл, -Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Өндөр	Дунд зэрэг
Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)	Төслийн үр шимийг хүртэгч гол байгууллага: Техникийн дизайн, төслийн удирдах хорооны гишүүнээр ажиллах	Өндөр	Дунд зэрэг

Оролцогч талууд	Төсөлд гүйцэтгэх үүрэг	Оролцоо	Нөлөө
Сангийн яам	Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын хэрэгжилтийг хангах	Өндөр	Өндөр
Эдийн засаг, хөгжлийн яам	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөгөө болон хөгжлийн стратегит тусгах Төслийг боловсруулах, Техникийн дизайн, зөвшөөрөл, төслийн удирдах хорооны гишүүнээр ажиллах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Өндөр	Дунд
Авлигатай тэмцэх газар	Төсөлд дэмжлэг үзүүлэх боломжтой мэргэжлийн байгууллага: Төслийг боловсруулах, Техникийн дизайн, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Өндөр	Бага
Худалдан авах ажиллагааны газар	Төсөлд дэмжлэг үзүүлэх боломжтой мэргэжлийн байгууллага: Төслийг боловсруулах, Техникийн дизайн, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Өндөр	Бага
Удирдлагын академи	Төсөлд дэмжлэг үзүүлэх боломжтой мэргэжлийн байгууллага: Техникийн дизайн хийхэд хувь нэмэр оруулах	Дунд	Бага
Боловсрол, шинжлэх ухааны яам	Төсөлд дэмжлэг үзүүлэх боломжтой мэргэжлийн байгууллага: Техникийн дизайн хийхэд хувь нэмэр оруулах	Дунд	Бага
Жижиг, дунд үйлдвэрийн газар	Төсөлд дэмжлэг үзүүлэх боломжтой мэргэжлийн байгууллага: Техникийн дизайн хийхэд хувь нэмэр оруулах	Дунд	Бага
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Уялдаа хангах, техникийн дизайн хийхэд хувь нэмэр оруулах	Дунд	Дунд
Нийслэл, аймгийн эрх бүхий байгууллагууд, тэдгээрийн харьяа төрийн үйлчилгээний байгууллагууд	Төслийг хэрэгжүүлэхэд оролцох, хувь нэмэр оруулах	Дунд	Бага

Төслийн удирдах хороо	Цахим хөгжил, харилцаа холбооны яам тэргүүлэх бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам зэрэг төслийн үр шимийг хүртэгч байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ. Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын дагуу төслийн хэрэгжилтийг ерөнхий удирдамж чиглэлээр хангах	Өндөр	Өндөр
Төсөл хэрэгжүүлэх нэгж	Төслийн хэрэгжилтийг ханган ажиллах	Өндөр	Өндөр
Гэрээт байгууллагууд	Төслийн түншүүд	Өндөр	Өндөр
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Зөвлөхүүд	Төслийн түншүүд	Дунд	Дунд

Оролцогч талууд	Төсөлд гүйцэтгэх үүрэг	Оролцоо	Нөлөө
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Орон нутгийн боловсрол, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд	Төслийн боломжит түншүүд	Дунд	Бага
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
ТББ-үүд, сонирхолын бүлгүүд	Төслийн боломжит түншүүд	Дунд	Дунд
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Үр шим хүртэгч төрийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Үр шим хүртэгч хувийн хэвшлийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Үр шим хүртэгч хот, суурин газрын оршин суугч иргэд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Төслийн үр шимийг хүртэж болзошгүй эмзэг бүлэг (үндэсний цөөнх, хөдөөгийн иргэд, эмэгтэйчүүд, тусгай хэрэгцээтэй иргэд, залуучууд гэх мэт)	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн яам	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага

Гэр бүл, хүүхэд хөгжлийн газар	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртөгч	Бага
Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хандивлагчид, хөгжлийн түншүүд	Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Өндөр	Бага

4. Аргачлал

Шилдэг туршлагын арга барилд нийцүүлэхийн тулд Төсөл нь сонирхогч талуудын оролцоог хангахдаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- *Нээлттэй байх ба амьдралын мөчлөгийн арга:* Төсөл (үүд)-ийн талаарх олон нийтийн зөвлөлдөх үүлзалтыг төслийн амьдралын мөчлөгийн туршид нээлттэй, гадны нөлөөлөл, хөндлөнгийн оролцоо, албадлага, айлган сүрдүүлгээс ангид зохион байгуулна.
- *Мэдээллээр хангагдсан оролцоо, эргэх холбоо:* мэдээллийг зохистой хэлбэрээр бүх оролцогч талуудад хүргэж, өргөнөөр түгээнэ; оролцогч талуудын санал хүсэлтийн талаар мэдээлэл, харилцаатай байх, гаргасан санал болон дэвшүүлсэн асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх боломжоор хангагдсан байх.
- *Хүртээмжтэй байдал ба мэдрэмж:* Төсөлд оролцох үйл явц нь нийтийг хамарсан байна. Нэгт, ТХН нь бүх оролцогч талуудад мэдээлэл хүртээмжтэй байх боломжоор хангах асуудлыг зохицуулна. Оролцогч талуудын хэрэгцээнд мэдрэмжтэй хандах нь оролцооны аргыг сонгоход баримтлах үндсэн зарчим юм. ТХН нь эмзэг бүлэг, ялангуяа өндөр настан, олон үндэстэн ястны бүлгүүд, тусгай хэрэгцээтэй иргэдийг хамруулах асуудалд онцгой анхаарна.
- *Уян хатан байдал:* Хэрэв хүн хоорондын зай барих нь оролцоог хангахад ашигладаг уламжлалт арга хэлбэрийг ашиглахад саад учруулахаар бол, оролцогч талуудтай харилцах бусад хэлбэр, тухайлбал, хувь хүнтэй утсаар шууд олбогдох, интернет харилцаа холбооны янз бүрийн хэлбэрийг ашиглах нь зүйтэй.
- *Талуудын оролцоог хангахад ашиглаж болох олон янзын арга бий.*

Үр дүнтэй, зохицсон оролцоог хангахын тулд санал болгож буй төслийн оролцогч талуудыг дараах үндсэн ангилалд хуваан авч үзэж болно. Үүнд:

Нөлөөлөлд өртөгч талууд – Төслийн нөлөөллийн орон зай буюу хамрах хүрээнд төслийн шүүд нөлөөлөлд (бодитойгоор эсвэл боломжит) өртөгч, /эсхүл төсөлтэй холбоотой өөрчлөлтөд хамгийн их өртөмтгий гэж тодорхойлсон, нөлөөлөл, түүний ач холбогдлыг тодорхойлох, түүнчлэн нөлөөллийг бууруулах, удирдан залах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад нягт хамтран ажиллах шаардлагатай иргэд, бүлгүүд болон бусад байгууллагууд.

Бусад сонирхогч талууд – Төслөөс шүүд нөлөөлөл үзүүлэхгүй байж болох ч өөрсдийнх нь ашиг сонирхолд төсөл нөлөөлсөн гэж үзэж байгаа болон /эсхүл төсөл болон түүнийг хэрэгжүүлэх үйл явцад ямар нэгэн байдлаар нөлөөлж болзошгүй хувь хүн /бүлгүүд /байгууллагууд; болон

Эмзэг бүлгүүд – эмзэг байдлын улмаас бусад бүлгүүдтэй харьцуулахад төсөл (үүд)-д пропорциональ бусаар өртөж болзошгүй, эсхүл цаашид эмзэг байдалд орж болох бөгөөд төсөлтэй холбоотой асуудлаар зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл явцад тэдний тэгш төлөөллийг хангахын тулд тусгай оролцоо шаардсан иргэд.

Гадуурхагдсан/эмзэг бүлгийн иргэд эсхүл бүлгүүд. Төслийн нөлөөлөл нь ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, бүлгүүдэд пропорциональ бусаар буюу харьцангуй бага нөлөөлж буй эсэхийг ойлгох явдал чухал. Эмзэг байдал нь тухайн хүний гарал үүсэл, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, эдийн засгийн гачигдал, санхүүгийн баталгаагүй байдал, нийгэм дэх сул дорой байдал (жишээ нь, цөөнх эсхүл фанатик бүлэг), бусад хүмүүсээс хараат байдал, эсхүл байгалийн баялгаас үүдэлтэй байж болно. Эмзэг бүлгүүд болон хувь хүмүүсийн оролцоог хангах нь төсөлтэй холбоотой шийдвэр гаргахад тэдний оролцоог хангахад тус дөхөм үзүүлэхүйц тусгайлсан арга хэмжээ, тусламж шаарддаг.

ННУ-ний дүгнэлтэд үндэслэн эмзэг болон гадуурхагдсан бүлгүүдийг баталгаажуулах шаардлагатай бөгөөд одоогийн жагсаалтад хэдийгээр эдгээрээр хязгаарлагдахгүй ч, дараах бүлгүүдийг багтаан авч үзэж болно. Үүнд:

- Залуучууд
- Эмэгтэйчүүд
- Ахмад настнууд
- Ядуу иргэд
- Бага орлоготой болон гагцхүү эцэг, эсхүл эхтэй өрхүүд
- Гэрэл, цахилгаанд болон эсхүл интернетэд холбогдоогүй түр оршин суугчид (хөдөөгийн шилжин суурьшигчид)
- Үндэсний цөөнх өрхүүд
- Тусгай хэрэгцээтэй иргэд (ТХИ)
- Жижиг бизнес эрхлэгчид

Эмзэг бүлгүүд гэдэг нь бусад бүлгийнхтэй харьцуулахад эмзэг байдлынхаа улмаас төсөл (үүд)-д харьцангуй бага хамрагдаж, эсхүл цаашлаад хохирч болзошгүй иргэд бөгөөд зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл явцад тэд тэгш төлөөлөлтэй байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд оролцоог хангах тусгайлсан хүчин чармайлт гаргах шаардлагатай байдаг.

Эмзэг байдал нь тухайн хувь хүн, эсхүл бүлгийн арьс өнгө, үндэс угсаа, нийгмийн гарал, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, өмч хөрөнгө, нас, соёл, бичиг үсэг тайлагдалтын байдал, өвчин эмгэг, бие махбодийн болон сэтгэцийн хомсдол, ядуурал, эдийн засгийн сул тал, байгалийн өвөрмөц нөөц, баялагаас хамааралтай байдал зэргээс үүдэлтэй байж болно.

Тусгай хэрэгцээтэй иргэдийн оролцоог хангах асуудал. Бүлэг нэг бүрийн хувьд, хүртээмжтэй мэдээлэл, харилцааны арга хэрэгсэл өөр өөр байдаг. Энэ хүрээнд дараах жишээг дурдаж болох юм. Үүнд:

- Сонсголын бэрхшээлтэй хүмүүст уулзалтын үеэр дохионы хэлээр орчуулга хийх шаардлагатай байж болно. Сонсголын аппарат ашигладаг хүмүүст гогцоо буюу давталтын систем шаардлагатай байж болно. Гогцоо систем нь ийм аппараттай хүмүүс томоохон хурал дээр яригдаж байгаа зүйлсийг сонсоход тус дөхөм үзүүлдэг.
- Сурах бэрхшээлтэй хүмүүст техникийн нарийн ширийн зүйлийг ойлгуулахын тулд баримт

- бичгийн уншихад хялбар (хялбаршуулсан) хувилбар шаардлагатай байж болно.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс хурал цуглааны үеэр гадуурхагдах вий гэсэн айдсаа даван туулахад нь туслахын тулд уулзалтаас урьтаж тэдэнтэй холбоо барих нь ашиг тустай байж болно. Гутаан доромжлолын талаарх санаа зовнилын асуудлыг шийдвэрлэх нь нийгэмд гадуурхагдсан бүх бүлгийг төслийн үйл ажиллагаанд хамруулахад тусална.
 - Хөдөлгөөний бэрхшээлтэй, тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэдийн тухайд, барилга руу орох налуу замтай байх, шатаар биш харин лифтээр явах боломжтой байх, барилга дотор хөдөлгөөн хийхэд нь хангалттай орон зайтай байх, тохиромжтой бие засах газартай байх шаардлагатай.

Зорилтот утга учиртай зөвлөлдөх уулзалт хийх боломжийг бүрдүүлэхийн тулд ТОХТ-г БОНС7-той нийцүүлэн бэлтгэж, төслийн үйл ажиллагаанд казах болон бусад үндэсний цөөнх иргэдийн үр дүнтэй оролцоог хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Казах хэлээр ярьдаг үндэсний цөөнхийн бүлэг нийт хүн амын 3.8 хувь, бусад жижиг цөөнх болон уугуул иргэд болох буриад, тува, урианхай, хотончууд нийт хүн амын 0.4-1.4 хувийг эзэлдэг тул соёлын хувьд зохистой оролцоог хангах үйл явцыг мөн харгалзан үзэх шаардлагатай.

5. Төслийн бэлтгэл ажлын явцад талуудын оролцоог хангах үйл ажиллагаа

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд төсөл хэрэгжүүлэгчийн үүргийг шилжүүлэхээс өмнө Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зүгээс төслийн нөлөөлөл, нөлөөллийг бууруулах механизм, үр өгөөжийн талаар өөр өөр санаа зовоосон асуудал, тэргүүлэх чиглэлтэй байж болох төслийн нөлөөлөлд өртөгч талууд болон бусад сонирхогч талуудын аль алинд нь харилцан адилгүй, эсхүл тусдаа оролцооны арга хэлбэрийг шаардаж болох янз бүрийн оролцогч талуудыг олж тодорхойлсон. Төслийг багцаалахын өмнө оролцогч талуудын “Талуудын оролцоог хангах төлөвлөгөө”-ний талаарх санал бодлыг авч үзэх, үүнд төслийн оролцогч талуудыг тодорхойлох, цаашдын оролцооны асуудлаарх санал зэргийг багтаасан ТОХТ-ний төслийг нээлттэй мэдээлсэн. Хэрэв ТОХТ-нд томоохон өөрчлөлт орсон бол түүний шинэчилсэн хувилбарын талаар цаашид мэдээлнэ. ННҮ-ний эрт үеийн санал дүгнэлтийг нэгтгэж, гол гол ярилцлага хийх хүмүүс, байгууллагын эхний байдлаар гаргасан жагсаалтыг баталгаажуулсан. 2021 оны 12-р сарын 22-ны байдлаар Дэлхийн банкны группийн зүгээс төслийн баримт бичгийг эцэслэхээс өмнө төслийн бэлтгэл ажлыг хангах явцад шигшилт хийгдэх жагсаалт болон зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, үүнийхээ талаар дараах хүснэгтэд нэгтгэн харуулсан.

Хүснэгт 3. Талуудын оролцоог хангах үйл ажиллагааны хураангуй (Энэ хэсэгт мэдээлэл нэмж оруулна)

Оролцогч тал	Сэдэв	Хэзээ	Санал хүсэлтийн хураангуй
Гүйцэтгэгч/хэрэгжүүлэгч болон үр шимийг хүртэгч байгууллагууд	Төслийн ерөнхий үзэл баримтлал, БОНХ болон түүний холбогдох арга хэрэгслүүдэд тавигдах шаардлага, БОНХ-ний баримт бичгийн төсөл, оролцоог хангах механизмыг хянаж үзэх асуудал	2021 оны 11-р сар	Энэ хэсэгт мэдээлэл оруулна.
Иргэний нийгэм болон иргэд, олон нийтийн бүлгүүд (эмэгтэйчүүд, залуучууд, тусгай хэрэгцээтэй иргэд, үндэсний цөөнх, орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчид, технологийн мэдлэгтэй хүмүүс, стартапууд, нөхөрлөл, ЖДҮ, орон нутгийн судалгааны байгууллагууд зэрэг гол гол зорилтот бүлгийн төлөөлөл)	Төслийн ерөнхий үзэл баримтлал, байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл болон нөлөөлөл.	2021 оны 11-р сар	Энэ хэсэгт мэдээлэл оруулна.
Засгийн газрын холбогдох байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа болон боловсролын байгууллагууд	Төслийн ерөнхий үзэл баримтлал, байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл болон нөлөөлөл.	2021 оны 11-р сар	Энэ хэсэгт мэдээлэл оруулна.

6. Мэдээллийг ил тод болгох

Эхний шатны Ухаалаг засаг төсөл (2015-2022) нь байгаль орчин, нийгмийн хамгааллын талаарх төслийн баримт бичгүүдийг ил тод болгох зорилго бүхий <https://www.smart.gov.mn/mn/> вэб хуудастай. ТОХТ, БОНАТ, ХМБОЖ, ХХЗЖ, ННҮ-ний төслийг хамгийн анхлан 2021 оны 11 сарын 26-ны өдөр энэхүү төслийн вэб хуудсанд байршуулж нийтийн хүртээл болгосон. Баримт бичгүүдийн төслийн талаарх санал хүсэлтийг нэгтгэж, шинэчлээд мөн олон нийтэд ил тод болгосон.

Үүнтэй адил нийтэд ил тод болгох баримт бичгүүдийн төслөөс (мөн, баримт бичгийн эцсийн хувилбар) гадна төслийн талаарх товхимолуудыг мөн нийтлэх болно. Нэмж дурдахад, уг вэб хуудсанд өргөдөл, гомдлыг барагдуулах буюу хянан шийдвэрлэх механизмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, ТХН-тэй холбоо барих хаягийг байршуулна. ТХН нь вэб хуудсыг тогтмол шинэчилж, тордоно.

Мэдээллийг олон нийтийн байнга зочилдог болон олон нийт саадгүй нэвтрэх боломжтой газруудад байршуулах замаар түгээнэ. ТХН-ийн оффист ТОХТ, БОНАТ, ХМБОЖ, ХХЗЖ, ННҮ-ний монгол хэл дээрх хувилбарын хуулбарыг олон нийтэд зориулан байршуулна. Мэдээллийг ил тод болгох стратеги боловсруулж, төслийн үйл ажиллагаа эхэлмэгц хэрэгжүүлнэ.

7. Хяналт-шинжилгээ ба тайлагнал

ТХН-д томилогдсон хамгааллын мэргэжилтэн нь талуудын оролцооны үйл ажиллагаанд хяналт

тавьж, тайлагнах үүрэгтэй ажиллана. ТХН нь ТОХТ-ний дагуу талуудын оролцоог хангах үйл ажиллагааг үргэлжлүүлэх бөгөөд уг үйл ажиллагаа нь оролцогч талуудтай нэгэнт тогтоосон харилцаа холбоо, оролцоог хангах сувгууд дээр тулгуурлана. Тодруулбал, ТХН нь төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэл, БОНАТ-ний нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн талаар оролцогч талуудаас санал авч байх болно.

Зөвлөлдөх уулзалтууд болон ил тод болгох үйл ажиллагааг мөн нэгтгэн дүгнэж, Дэлхийн банкинд төслийн хагас жилийн ажлын тайланд тусгах замаар тайлагнана. Гүйцэтгэлийн хэд хэдэн гол үзүүлэлтүүдийг (ГГҮ) ТХН-аас тогтмол хянаж байх бөгөөд үүнд дараах үзүүлэлтүүд орно:

- Тайлант хугацаанд хийсэн зөвлөлдөх уулзалт болон бусад олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг/чуулганы тоо (жишээ нь, сар, улирал, жилээр).
- Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны давтамж.
- Тайлант хугацаанд хүлээн авсан олон нийтийн өргөдөл гомдлын тоо (жишээ нь, сар, улирал, жилээр) болон тогтоосон хугацаанд шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо.
- Хүлээн авсан олон нийтийн өргөдөл гомдлын төрөл; болон
- Үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтлэгдсэн/хэвлэгдсэн материалын тоо.

8. Гомдол барагдуулах механизм

Гомдол барагдуулах механизм (ГБМ) нь нөлөөлөлд өртөгч иргэн/олон нийтийн байгаль орчин, нийгэмтэй холбоотой гомдол болон асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй аргыг санал болгодог. ГБМ-ыг олон нийттэй зөвлөлдөх уулзалт хийх үеэр танилцуулж байх ба төслийн түршид монгол хэл дээр оролцогч талууд, олон нийт танилцах боломжоор хангана. Гомдол гарсан тохиолдолд, асуудлыг дараах байдлаар 4 хүртэлх үе шатанд хянан шийдвэрлэнэ. Үүнд:

- 1 дэх үе шат: Орон нутгийн түвшинд шийдвэрлэх болон ГБМ-д хандах. ГБМ-ын тогтолцоо нь нөлөөлөлд өртөгч иргэдэд (орон нутгийн оршин суугчид, орон нутгийн аж ахуйн нэгжийн төлөөлөл, гэрээт ажил гүйцэтгэгчдийн ажилчид гэх мэт) тухайн үед мөрдөгдөж буй Засгийн газрын горим журмын хүрээнд тусгай зориулалтын шууд утсаар, биечлэн, цахим шуудангаар дамжуулан өргөдөл гаргах зэрэг хэд хэдэн хувилбараас хамгийн тохиромжтойг нь сонгон гомдол, санал хүсэлт гаргах боломж олгодог. Гомдлын бүртгэл нь сэтгэгдэл/гомдол гаргасан асуудал, нөлөөлөлд өртсөн иргэний нэр, холбоо барих хаяг, гомдол гаргасан огноо гэх мэт дэлгэрэнгүй мэдээллийг багтаана.
- 2 дох үе шат: Гомдол шалгуурыг үнэлэх, хянан шийдвэрлэх. Хүлээж авсан гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг ТХН-ийн холбогдох ажилтан, эсвэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны холбогдох газар/хэлтэс/албанд хариуцуулна. ТХН асуудлыг шалгаж шийдвэрлэх алхам хийж байх хэрэгтэй. Энэ нь гэрээт ажил гүйцэтгэгчид засч залруулах арга хэмжээ авах зааварчилгааг агуулсан байж болно. Гэрээт ажил гүйцэтгэгч нь гомдлыг барагдуулах шийдлийг хэрэгжүүлж, үр дүнг ТХН-д уламжилж, энэ талаар ДБ-д мэдэгдэх ёстой. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон ТХН нь гомдол гаргасан асуудлын төрөл, нарийн төвөгтэй байдлаас хамааран гомдлыг хүлээн авснаас хойш 1-30 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

3 дахь үе шат: Төслийн удирдах хорооны түвшинд гомдлыг хянан шийдвэрлэх. ТУХ нь шаардлагатай тохиолдолд, 3 дахь үе шат эхэлсэнээс хойш 10 хоногт багатаан олон талт оролцогч талуудын уулзалт хийх боломжийг судалж, зохион байгуулах арга хэмжээ авна.

4 дөх үе шат: Дээд түвшний эрх бүхий байгууллагын шугамаар асуудлыг хянан шийдвэрлэх. Гаргасан гомдлыг нь хянан шийдвэрлээгүй тохиолдолд, нөлөөлөлд өртсөн талууд шүүхэд хандан хохирлоо барагдуулах боломжтой.

Анхны Ухаалаг засаг төсөл нь олон нийтэд зориулсан гомдол барагдуулах тогтсон механизмтай байсан (ГБМ) бөгөөд үүнийг дараагийн төсөлд ашиглах болно. ТХН-ийн зүгээс өөрт нь хандаж мэдээлсэн санаа зовнихуйц бүх асуудлыг бүртгэж, хэрэгжиж буй/эхний төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэгдсэн тохиолдлуудад нэмэлт шалгалт хийх шаардлагатай эсэхийг, эсхүл бие даасан арга хэмжээ авахад хамааралгүй гомдол гэж үзэн шилжүүлэх эсэхийг тогтооно. Эхний төслийн хүрээнд шалгалт хийгдсэн бол ТХН-ийн зүгээс харилцан тохиролцсон нөлөөллийг бууруулах арга хэмжээнд үнэлгээ хийж, гомдол гаргагчтай зөвлөлдөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. 2015 оны 9-р сараас хэрэгжиж буй/анхны төсөл хэрэгжиж эхэлснээс хойш гаргасан өргөдөл гомдлыг шүүд харилцах тусгай 6 сувгаар, бичгээр, цахим шуудан, төслийн вэб хуудсын санал хүсэлтийн хэсэг, төслийн фэйсбүүк хуудас, твиттер, инстаграм, биечилсэн уулзалт зэргээр дамжуулан хүлээж авч ирсэн. Төслийн ГБМ-ыг одоо байгаа систем дээр үндэслэн үр дүнтэй удирдах боломжтой. Төслийн бүх үе шатад төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын зүгээс төслийн нөлөөлөлд өртөгч хувь хүн болон/эсхүл бусад сонирхогч талуудын оролцоог илүүтэй хангахад нь тус дөхөм үзүүлэх зорилгоор ТХН-ийн ГБМ-ын журмыг боловсронгуй болгож болно.

ТХН нь дараагийн төслийн холбогдох гомдлын талаархи гомдлын тайланг үйлдэх ба дор дурдсан гомдлын бүртгэл буюу логийг шаардлагатай үед төсөлд ашиглаж, мөн шинэчлэн өөрчилж болох юм.

Хүснэгт 4. Гомдлын бүртгэлийн маягт

Но.	Статус буюу төлөв	Хүлээж авсан огноо	Иргэн/иргэд	Гомдлын төрөл ба хүлээж авсан суваг	Гомдлын агуулгын хураангуй	1 дэх түвшинд хянан шийдвэрлэсэн төлөв ба хаасан огноо	2 дох түвшинд хянан шийдвэрлэсэн төлөв ба хаасан огноо	ТХН-ийн асуудал хариуцуулсан ажилтан
1								
2								

Ямар ч үед, төслийн гомдол барагдуулах механизм асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзвэл Дэлхийн Банкны Гомдол хянан шийдвэрлэх алба болон Дэлхийн Банкны Хяналт шалгалтын комисст хандан давж заалдаж болно. Дэлхийн банкны Байгууллагын гомдол хянан шийдвэрлэх албанд (ГХША) хэрхэн өргөдөл гомдол гаргах тухай мэдээллийг <http://www.worldbank.org/GRS> хаягаас авах боломжтой. Дэлхийн банкны Хяналт шалгалтын комисст хандан хэрхэн өргөдөл гомдол гаргах тухай мэдээллийг www.inspectionpanel.org хаягаар орж авах боломжтой.

9. Байгаль орчин, нийгмийн менежментийн чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө

Дэлхийн банкны БОНХ-ний шаардлагууд 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн тул, төсөл хэрэгжих явцад байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан наад зах нь нэг ажилтантай байх шаардлагатай ба хэрэв шаардлагатай тохиолдолд эрэлт хэрэгцээндээ тулгуурлан гаднаас байгаль орчин, нийгмийн асуудал хариуцаж ажиллах зөвлөхүүдийг сонгон шалгаруулж авна. ДБ-ны БОНХ-ын БОНС-ын дагуу БОНХ-ийн арга хэрэгслийг бэлтгэх хүн хүч бэлтгэгдээгүй байгаа тул тэдний чадавхийг дээшлүүлэхийн тулд энэ чиглэлийн дотоодын мэргэжилтнүүдийн туслалцааг авах шаардлагатай болно. Төслийн эхний сараас 12 сарын хугацаанд үр дүнтэй ажиллахын тулд ДБ-ны хамгааллын багийн дэмжлэгтэйгээр олон улсын болон үндэсний мэргэшсэн зөвлөхүүд БОНХ-ний сургалт хийх шаардлагатай. БОНХ болон БОНС-ууд нь гэрээт ажил гүйцэтгэгчдийн үр дүнтэй гүйцэтгэлийг хангахад зохих анхаарал хандуулахыг шаардах тул эдгээр асуудлаар тусгайлсан сургалт зохион байгуулах шаардлагатай.

БОНХ-ний талаарх сургалт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа нь БОНХ-ний тухай үндсэн ойлголт, менежмент, БОНС-ууд, шигшилт хийх, эрсдэлийн үнэлгээ, БОНАТ, ТОХТ, ХМБОЖ болон ХХЗТ-ын хэрэгжилт, ялангуяа гэрээт ажил гүйцэтгэгчийн менежмент ба хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, талуудын оролцоог хангахтай холбоотой БОН-ийн хяналтын талаарх мэдлэг, ойлголт өгөхөд чиглэгдэх ёстой. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментэд анхаарал хандуулсан зорилтот сургалтын хөтөлбөрүүд нь байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлж болох юм.

Төсөл хэрэгжих үе шатанд төрийн байгууллагууд болон холбогдох оролцогч талуудад БОН-ийн асуудлаар сургалт явуулж, зааварчилгаа өгнө. Сургалтын гол сэдвүүд нь дараахь зүйлийг агуулж болно. Үүнд:

- БОНАТ, ТОХТ, ХМБОЖ болон ХХЗЖ-д төвлөрсөн БОН-ийн арга хэрэгслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах БОН-ийн үйл явц ба удирдамж,
- БОНАТ, ТОХТ, ХМБОЖ, ХХЗЖ-ын төлөвлөлт, хэрэгжилт болон ГБМ-ыг ашиглах талаар тусгайлсан сургалтууд,
- Төсөлд ашиглах маягтууд, тайлагнах үйл явц болон орон нутгийн иргэдэд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах зорилготой эрүүл мэнд, аюулгүй байдал, жендэр, хүртээмжтэй байдлын талаарх үндсэн мэдлэг, ойлголт, эрчим хүчний хэрэглээг бууруулах, хог хаягдлын цахим менежментийн шилдэг туршлага, ГБМ-ын горим журам болон ЖСХ, КОВИД-19 болон бусад халдварт өвчинтэй холбоотой нийгмийн асуудлууд зэргийг багтаасан гэрээт ажил гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх, хяналт тавих талаар тусгайлсан сургалт

Эхний 2 жилийн хугацаанд, үр шимийг хүртэгч байгууллагууддаа жилд 2-оос доошгүй удаа БОНХ, хамгааллын баримт бичгүүд, ялангуяа, БОНАТ, ТОХТ, ХХЗЖ, ХМБОЖ-ыг боловсруулах хэрэгцээ, шаардлагатай холбоотой сургалт семинар зохион байгуулж байхыг ТХН-д зөвлөмж болгож байна. Эхэн үеийн хөтөлбөрт зориулсан үндсэн сургалтад хамрагдвал зохих тодорхой зорилтот бүлгүүдийг Хүснэгт 5-д санал болголоо.

Хүснэгт 5. Төсөл хэрэгжиж эхлэх шатанд зохион байгуулах хамгааллын талаарх сургалт

No	Агуулга	Сургалтанд хамрагдах зорилтот бүлгүүд
1	БОНХ-ний үзэр баримтлал, БОНС-үүд, БОНАТ, ТОХТ, ХХЗЖ, ГБМ болон ХМБОЖ-ыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах	ТХН, үр шимийг хүртэгч байгууллагууд, зөвлөхүүд эсхүл зөвлөх компаниуд
2	Гэрээний удирдлага, чадавхийг сайжруулах асуудлыг багтаасан БОНАТ, ТОХТ, ХХЗЖ бэлтгэх, хяналт тавих асуудал	ТХН, үр шимийг хүртэгч байгууллагууд, зөвлөхүүд эсхүл зөвлөх компаниуд болон гэрээт ажил гүйцэтгэгчид
3	Байгаль орчин, нийгмийн хяналт тавих үр чадварыг сайжруулах	ТХН, гэрээт ажил гүйцэтгэгчид, байгаль орчин, нийгмийн зөвлөхүүд, Засгийн газрын холбогдох эрх бүхий байгууллагууд

Тус арга хэмжээний хүрээнд 100,000 ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг төслийн 4-р бүрэлдэхүүн хэсгээс Талуудын оролцоог хангах төлөвлөгөө болон Санал гомдол шийдвэрлэх механизм-ийг дэмжих, зөвлөгөө өгөх, төслийн баримт бичгийг холбогдох талуудад танилцуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулна.